

20-р ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН АР МОНГОЛ
ДАХЬ ШИНЭТГЭЛИЙН БОДЛОГО

*Хэрээд Ж. Урангуа**

XX зуун гэдэг бол одоо бидний амьдарч буй эрин үе билээ. Энэ зуунд хүн төрөлхтөн дэвшин ороход Европ, Америк тивийнхэн хөгжлийн нилээд өндөр түвшинд, харин Ази Африкийн орнууд нь Дэлхийн капиталист аж ахуйн тариалан түүхий эдийн хавсарга болон хүчээр татагдан орсон үе байлаа.

Монгол орон нь 200 гаруй жил манжийн ноёрхолд байсан ч төр ёсны уламжлалаа орхиж, харийн ёсонд автагдаж уусаагүй, харин ч дарлан мөлжигчдөө тухай бүрд нь эсэргүүцэж, үндэсний нэгдэл, төрийн тусгаар тогтнолоо сэргээх сайн тухайг эрэлхийлж байсан билээ.

Манж нар анхнаасаа Монгол орныг гадаад ертөнцөөс тасархай, битүү бөглүү барьж байхад чиглэсэн бодлого явуулсан нь XIX зууны 2-р хагасаас өөрчлөгдсөн нь юуны өмнө Чин улс дэлхийн улсуудаас хоцрогдсоноо арилгахын тулд улсын хэмжээгээр заримда хөрөнгөтний маягийн шинэтгэлийг эзэн хаант төрийн байгуулалд халгүйгээр хийх гэсэн оролдлоготой холбоотой. Түүнийгээ шинэ бодлого гэж нэрлэсэн бөгөөд тэр нь Монгол орны нөхцөлд хэрэгжихдээ “Шинэ засгийн бодлого” гэж нэрлэгджээ. Манж Хятадуудын дээрх шинэ бодлого нь дараахь учир холбогдолтой юм. Үүнд: Нэгдүгээрт Чин улсын зах хязгаар болж байсан нутаг орныг гадаадынханд алдахгүйн тулд хятад тариачдын асуудлыг шийдвэрлэнэ. Хоёрдугаарт: Манж Чин улс империалист гүрнүүдийн хагас колони болсон нөхцөлд, Монгол мэтийн хятад биш угсаатнуудыг урьдын адил бөглүү байлгах боломжгүй болж ирсэн. Ийм нөхцөлд Монгол орныг юуны урьд Хятадуудад нээлттэй болгох үүднээс. Гуравдугаарт: Чин улсаас харийн түрэмгийлэгч гүрнүүдийг эсэргүүцэж хийсэн дайнууд тухай бүр ялагдсаар төгссөн тул дайны үлэмжхэн төлбөрийг төлж дуусгах зэрэгт дээрх бодлого чиглэгдэж байлаа.

Манж Чин улсын засгаас 1901-1905 онуудад зарлан явуулсан шинэчлэл нь хожимдсон зүйл байлаа. Хэрэв хэдэн жилийн өмнө “Шинэчлэлийн 100 өдөр”⁽¹⁾-ийн үед эзэнт хаант төр нийгмийн шинээр төрж буй дэвшилтэт хүчнийхний шаардлагуудыг хүлээн авч шинэтгэл хийсэн бол цаг үеэ олсон зүйл болох байсан бөгөөд ядаж манж нарын засаглалын нэр хүндийг дээшлүүлэх байлаа. Гэтэл Манж Чин улс өрнөдийн гүрнүүдэд ичгүүргүй бууж өгсөн үед (1900-1901)⁽²⁾ “Шинэ засгийн бодлого нь Манж нарын доройтлын илэрхийлэл болж улмаар өргөн олон түмний дургүйцлийг улам ихэсгэсэн. Энэхүү байдал нь уг шинэчлэлийн хувь заяаг тодорхойлсон ажээ.

Шинэ засгийн бодлого бол Манж Чин улсын хэмжээгээр явагдсан юм. Тэр үед Монгол орон түүний ноёрхолд байсан болохоор мөнхүү бодлого бас л монголд холбогдолтой. Тэгэхдээ нилээд өвөрмөц онцлогтой бөгөөд XX зууны эхээр монгол оронд болсон үйл явдлууд Шинэ засгийн бодлоготой шууд холбогдож гарсан гэж үзүүштэй.

Шинэ засгийн бодлогын улс төрийн салбарт хийсэн шинэтгэлүүдээс нилээд тууштай явагдсан нь цэргийн шинэтгэл юм.

*Монгол Улсын Их Сургуулийн ахлах багш, түүхийн ухааны дэд доктор.

Монголд шинэ маягийн цэрэг төсөвлөн боловсруулах саналыг Их Хүрээний сайд Сань До Чин улсын засгийн газар тавьсан нь Монголын тусын тулд биш харин Чин улсад цэргийн хүчин яаралтай хэрэг болох үед ашиглах бодлогын үүднээс хийгдэж байв.

Чин гүрэн даяар үндсэн хуулийн байгуулалд шилжиж улсын хурлыг хуралдуулж үндсэн хууль нэн даруй батлахыг шаардсан хөдөлгөөн хүчтэй өрнөж байсан үед Бээжинд Засагт тус хийх яамны анхдугаар хуралдаан болж хятад хэлэлцэгч түшмэд нар улсын хурлыг хуралдуулах шаардлага тавьж байхад харин түүнд оролцсон Монголын төлөөлөгчид шинэ засгийн бодлогоор монгол газар хэрэгжүүлэх гэж байгаа бүх арга хэмжээ, нэн ялангуяа эдийн засгийн талаар төлөвлөж байсан зүйлийг эрс эсэргүүцэх чиглэлтэй байсан. Энэхүү хуралдаанд болон түүний дараах хуралдаанд оролцсон монгол түшмэдүүд Монголд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээг айлтгал гуйлтаар болиож чадахгүй нь гэдгийг ойлгосон учир гэдрэг буцахыг яаравчлах болон хуралд оролцохоос булзаарч үлдсэн юм.⁽³⁾

Чин улсын төрөөс сэдэж хэрэгжүүлж эхэлсэн улс төрийн шинэчлэл нь их төлөв эзэн хаант төрийн засаглалын асуудлыг хамарч байсан. Орон нутгийн тухайлбал: Хятад ба хятад бус олон угсаатны эрхийн асуудал хөндөх дөхөөргүй ерөнхий утгаар яригдаж байжээ. Тиймээс орон нутаг дахь улс төрийн бодлого тууштай хэрэгжээгүй, нөгөө талаар дараагийн хэрэг явдлуудаар тасалдсан билээ. Шинэ засгийн бодлогод эдийн засгийн арга хэмжээ чухал суурийг эзэлж байсан нь Чин гүрний тухайн үеийн эдийн засгийн байдлаар тайлбарлагдаж Монгол мэтийн хятад бус угсаатны хувьд гэвэл нутаг орныг нь Хятад тариачин иргэдээр дүүргэж, тариаланг ирмүүн хөгжүүлэх, байгалийн баялагийг ашиглах, үйлдвэр байгуулах, худалдаа, зам тээвэр хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд төлөвлөсөн нь Хятадын олон мужид байгалийн гамшиг тохиолдож ургац алдсаны улмаас үй олон тариачид хүнс тэжээлийн хүнд байдалд орсныг шийдвэрлэх, нөгөө талаар империалист орнуудад төлөх үлэмжхэн хэмжээний дайны төлбөрийг төлөхийн тул аль болохоор их ашиг олох шаардлагатай байсны үүднээс хийх зорилготой байсан. Мөн Орос-Японы дайны дараа Ар Монголд өнгөлзөх болсон Хаант Оросын нөлөөг хаахын тулд Орос улстай хил залгаж байгаа бүх нутагтаа хятад тариачдаар тариа тариулан суурьшуулах давхар зорилготой байжээ.

Эдийн засгийн салбарт явуулах бодлогоо хэрэгжүүлэхийн үүднээс Манжийн төр урьдчилан Монгол орны аж ахуй, ан агнуур, ашигт малтмалын талаар судлах, мэдээ сэлт гаргуулах ажлыг зохион байгуулсан.⁽⁴⁾ Ер нь улс төрийн салбарт зарим нэг зүйлийг хийсэн явдал нь эцсийн бүлэгт эдийн засгийн салбар дахь бодлогыг хэрэгжүүлэхийн үүднээс хийгдсэн болох нь илэрхий.

Эдийн засгийн салбарт хийх шинэчлэл нь эцсийн бүлэгт монгол орны бэлчээрийг хагалбарлаж тариалангийн талбай болгон үй олон Хятад иргэдийг ирүүлэн суурьшуулахад чиглэсэн нь хятад иргэдийн хувьд туйлын ашигтай боловч Монголын тухайд маш харгис бодлого байлаа.

Чин улсын колоничлох бодлого идэвхжиж олон хятад байгууллага үүсч, Хятад иргэд олширсон нь Хятадын мөнгө хүүлэгч худалдаа улам өргөсч, мөлжлөг нь ширүүссэн. Монголын ашигт малтмалд гадаад улсууд их олзуурхаж байсантай өрсөлдөж монголын ашигт малтмалын

орд газрыг хайж сурвалжлах ашиглах талаар ихээхэн анхаарсан, мөн өөрсдийн эрх ашгийн үүднээс сургууль, хэвлэл, шашин шүтлэгийн талаар бас өөрчлөлт хийж байсан. Тухайлбал сургууль байгуулах явдал нь Манж Хятад хэл бичигтэй хүмүүс хэрэгцээтэй болсны улмаас хэвлэн гаргах болсон нь үзэл суртлын асуудалтай холбогдон гарч байсан нь Монголчуудын эрх ашгийн үүднээс хийгдэж байсан зүйл огт үгүй.

Ер нь Шинэ засгийн бодлого гэгч нь түүний ноёрхолд байсан монгол, Хятад, түвд, уйгур, хотон зэрэг олон угсаатны дотор Манжийн ноёрхлыг түлхэн унагаж үндсэр чөлөөлөхийн төлөө хувьсгалт тэмцэл тасралтгүй гарах болсон үед ардчилсан шинэчлэл хийж байгаа дүр үзүүлэн, тэднийг хуурч мэхлэн тэмцлээс нь ухраан, ноёрхолоо бэхжүүлэх, чингэхдээ гадаадын империалист гүрнүүдийн өнгөлзлөгөөс улс орноо аварч цэцэглүүлэн хөгжүүлнэ гэдэг нэрийдлээр хятад биш угсаатныг хүчээр хятадчилах гэсэн туйлын бурангуй бодлого юм. Манж нарын энэхүү бодлого нь Хятадын үндэсний бодлого болсон. Гэхдээ энэ нь олон түмний хувьсгалаас айдаг Хятадын хүнд сурталт түшмэд, үеэ өнгөрөөж буй эзэнт хаант төрд бөхөлзөн бялдуучлагч газрын эзэд 3, 1 либерал хөрөнгөтний бодлого мөн. Иймээс тэр үед хувьсгалт тэмцлээр Чин улсын төрийг түлхэн унагахыг эрмэлзэж байсан. Хувьсгалт ардчилсан хүчнүүд “шинэ засгийн бодлогыг” эсэргүүцэж байлаа.

Шинэ засгийн бодлогыг монголчууд анхнаасаа дургүйцэн угтаж, түүнийг зүйл бүрээр эсэргүүцэж байсан. Энэхүү шинэтгэл бүрэн хийгдэж амжилгүй 1911 оны хувьсгалт тэмцлээр тасалдсан юм.

II

Хэдэн зуун жил алдсан тусгаар тогтнолоо монголчууд олохын тул Хаант Оросын тус дэмжлэгийг авахад хүрсэн юм. Улс байгуулсныхаа дараа олон улсыг түшиглэн тусгаар тогтнолоо бэхжүүлэх бодлого явуулах оролдлого хийсэн билээ.

Улс орны дотоод бодлого нь гаднаас ямар нэг гүрэн тулган хүлээлгэсэн бус харин өөрийн хөрснөөс, дотоод хөгжлийн шаардлагаар дэвшигдэн гарч ирсэн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, монголын ард түмний эрх ашигт нийцсэн дэвшилтэт зүйл байсан.

Төрийн эрх мэдэл монголчуудын гарт шилжихдээ феодалын хаант төрийн хэлбэрээр хэрэгжсэн ажээ. Үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдлагыг анхнаасаа дээд ноёд, лам нар олон түмний хувьсгалч идэвхийг түшиглэн гартаа авч улмаар эзэн хаант төрийн шашин төрийг хослон барьсан засаглалыг тогтоосон. Гэхдээ 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалаар Монголд тогтсон хаант төрийн үйл ажиллагаа нь түр боловч колоний дэглэмийг түлхэн унагааснаараа нийт үндэстний ач холбогдолтой байсан юм.

Шинэ байгуулагдсан монголын тусгаар тогтносон улсыг төвхнүүлэхийн тулд зарим шинэ арга хэмжээ буюу шинэтгэлийг заавал хийх шаардлагатай байлаа. Иймээс тэр үеийн Монголын тэргүүний хүмүүсээс феодалын алба гувчуурыг хөнгөтгөх, ард түмний аж ахуйн санаачлагыг тэтгэх, ардын доторхи эрдэмтэй чадалтай хүмүүсийг язгуур угсаа харгалзахгүйгээр улс төрийн үйл ажиллагаанд оролцуулах, өөрийн цэрэг цагдаатай болох, иргэний сургууль соёлын ажлыг хөгжүүлэх шаардлагыг тавих нь хүчтэй болсон ба нөгөөтэйгүүр эрх баригчдын ухамсартай хэсэг нь энэ мэтийн шинэтгэлийг хийхгүйгээр

урагш хол явахгүй гэдгийг ухаарч, мөн тусгаар тогтносон улс орноо явал түргэн өөд татаж, бусдын гар харахгүй биеэ дааж хөгжих билээ гэсэн эх оронч үзэл санаа монголын нийгмийн сэтгэлгээнд товойн гарч байсан зэрэгтэй холбоотой.

Ингээд улс төрийн салбарт хийсэн шинэтгэл нь төрийн хэлбэр, орон нутгийн захиргааны бүтэц, үйл ажиллагааны үндсэн чиглэл, улс төрийн гадаад бодлого, хууль цааз, арми, шүүхийн систем зэрэг хүрээг хамарсан.⁽⁵⁾

Төрийн зохион байгуулалтын хэлбэрт хийсэн шинэтгэл болох улсын хурлын хоёр танхимтайгаар байгуулсан явдал бол хаант улсын удирдлагын бүтцэд орчлөлт хийх замаар төрийн удирдлагад үүссэн зөрчлийг шийдвэрлэхийг зорьсон гэж үзэж болох юм. Учир нь уг байгууллагыг сонгуулийн бус замаар бүрэлдүүлсэн эзэн хааны дэргэд түүнд зөвхөн зөвлөх эрхтэйгээр байгуулснаас үзэхэд илэрхий. Гэхдээ улсын хурлыг байгуулсан нь ерөөс дэлхийн бусад орны нөлөө туршлагаас гадна шинэ засгийн бодлогын үед улсын хурлын тухай яригдаж, хийгдэж байснаас санаа авсан зүйл байсан гэж үзэх үндэстэй юм. Утсын дээд доод хурал нь тэр үеийн монголын нийгэм дэх хүчнүүдийн үзэл санаагаа илэрхийлэх талбар болсон бөгөөд нийгмийн дэвшилт хүчнүүд улсын хурлыг өөрсдийн шинэтгэлийн үзэл бодлогыг биелүүлэхэд ашиглахыг оролдож байсан нь Монгол оронд үндэсний ардчилсан үзэл санаа дэлгэрүүлэгч болгож байв.

Улс төрийн салбар дахь шинэтгэлийн үр дүнд нилээд шинэ зүйл буй болов. Тухайлбал: улсын дээд доод хурлаар “Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-ийн зарим дэвтрийг хэлэлцэх үед гарсан саналын дагуу хуулийн төсөл зохиох комисс харгалзан үзэж орчлөлт оруулсан нь хуулийн төслийг хэлэлцэхэд нилээд олон хүн оролцож, ингэснээрээ олон түмний санааг ямар нэгэн хэмжээгээр илэрхийлэх болсон. Мөн аймаг, хошуу болон бусад засаг захиргааны албан тушаалтнуудыг томилох, халах явдлыг Ар Монголын эрх баригчид гүйцэтгэдэг болсноороо урьдах үеэс ялгаатай байв.

Аливаа нийгэмд хууль нь нийгмийн харилцааг зохицуулагч хэрэгсэл болдог билээ. Энэ утгаараа “Зарилгаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичгийн 65 дэвтэрт эмхтгэл нь Монгол улсын засгийн газрын бодлогыг харуулсан хууль цаазын дурсгал болно. Нийгмийн амьдралын олон талтай янз бүрийн харилцааг Монголын хаант улс богино хугацаанд хуулиар зохицуулж чадсан нь чухал шинэтгэл байлаа. Үүний зэрэгцээгээр хууль тогтоомжинд Монгол орны анги, булгийн эрх ашигт эрс ялгавартай хандсанаараа феодалын нийгмийн дотоод зөрчил улам хурцтах нэгэн нөхцөл шалтгааныг бүрдүүлсэн ажээ.

Монголын хаант улс нь хууль тогтоомжийг шинэчлэлээс гадна шүүх болон байцаан шийтгэх ажиллагаанд шинэтгэл хийж амжсан билээ. Үүнд шүүхийн олон шатны систем бий болгосон нь орон нутаг дахь засаг ноёдоос ард түмний эсрэг өөрсдийн дур зоргоор санаа бодлоо тулган хүлээлгэхэд нөлөөлж чадахгүй ч, шударга үнэний төлөө шат ахиж заргалдан тэмцэх эрх олгосноороо дэвшилт үзэгдэл байв.

Улс төрийн салбарт хийсэн чухал шинэтгэл бол үндэсний цэргийн анги байгуулсан явдал болно. Эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах эрх ашгийн үүднээс байгуулагдсанаараа өмнөх манжийн үеийн цэргээс ялгаатай. Засгийн газар өөрийгөө хамгаалах хүчин мөхөс

байдлаа харгалзаж Орос улсыг түшиглэхэд хүрсэн бөгөөд түүнээс тусламж авч цэргийн сургалт, зохион байгуулалтдаа Европ маягийн өөрчлөлт оруулж хэрэгцээтэй үедээ татаад дараа нь тараадаг биш, тодорхой хугацаагаар ээлжлэн алба хаадаг байнгын цэргийн эхлэл тавьсан нь дэвшилтэй зүйл болжээ.

Шашин төр хосолсон монгол улсын оршин тогтнож байсан тэр үе нь ахархан боловч нийгэм, эдийн засгийн хувьд нилээд ахиц өөрчлөлт гарсныг чамлаж болохгүй бөгөөд эдийн засгийн талаар явуулсан бодлого, арга хэмжээ тухайн үедээ нилээд дэвшилтэй зүйл байсан нь маргаангүй. Улсын санхүүг бэхжүүлэх үүднээс орлогын шинэ эх үүсвэр бий болгоход чиглэсэн арга хэмжээнүүд газар тариалангийн ажлыг хөгжүүлэх, улс орны баялгийг ашиглах, харилцаа холбоог хөгжүүлэх талаар нилээд арга хэмжээ авсан билээ.⁽⁶⁾ Улс орны санхүүгийн хүчин чадал хомс байсны улмаас дээрхи салбаруудад шинэтгэл хийхэд хүрэлцэхүйц хэмжээний мөнгөн хөрөнгийг гаргаж чадахгүй байсан нь эдийн засгийн салбар дахь шинэтгэлийн хувь заяанд нөлөөлсөн юм. Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь, орлогыг төдийлөн нэмэгдүүлж чадаагүй. Тиймээс ч Монгол улсын засгийн газар гадаад орноос зээл авахад хүрсэн бөгөөд зээллэг болгоны дараа Орос улсад Монгол нь ямар нэгэн буулт хийдэг байжээ. Мэдээж Орос нь өөрийн хөрөнгө оруулалтыг чөлөөтэй болгоход чиглэсэн зүйлийг тулган хүлээлгэж байсан.⁽⁷⁾

Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс хийсэн шинэтгэлд учир дутагдалтай зүйлч нилээд байв. Тухайлбал: дотоод худалдаанаас хураах хураамж нь гадаад худалдаанаас хураах гаалийн хэмжээ, газар ба ашигт малтмалын түрээсний хөлснөөс их байсан. Энэ нь эсрэг байвал өргөн олон түмэнд ашигтай л байхсан. Нөгөө талаар дотоод дахь худалдаанаас гаалийн татвар авахын зэрэгцээ зарим зүйлийг онцлон авч үзэж зарим салбарын худалдааг гаалиар ивээн тэтгэх (протекционизм) бодлого явуулсан бол ашиг өгөхүйц юм. Жишээлбэл зарим нэг зүйлийн худалдааг урамшуулах үүднээс гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх, зарим нэгэнд нь онцгой татвар тогтоох зэргээр гаалийн уян хатан бодлого явуулсан бол дотоод зах зээлийн хөгжилд түлхэц болж, зарим үйлдвэрлэлийг дэмжин тэтгэх үндэс болох байсан.

Эдийн засгийн салбарт хийсэн шинэтгэл нь монголын нийгэмд шинэ шинэ үзэгдлүүд гаргахад хүргэсэн. Таваар мөнгөний харилцааг дэлгэрүүлж, тэр нь аж ахуйн хувиа аргацаасан байдлыг эвдэж жижиг таваарын аж ахуй үүсэн хөгжихөд түлхэц болжээ. Энэхүү жижиг таваарын аж ахуй дэлхийн капиталист аж ахуйтай нягт холбоотой үүссэн нь монголын феодалын нийгмийн харилцааг улам задалж, хөгжлийнхөө ерөнхий хандлагаар шинэ, харилцааны үр хөврөл бий болох хөрс дэвсгэр болж байв. Ер нь ХХ зуунд эдийн засгийн хувьд үндэсний хэвчээ бараг байхгүй болсон ажээ. Жижиг орны эдийн засгийн явдал (улс төрийн нэгэн адилаар) олон талаар гадаад хүчин зүйлээс шалтгаалдаг. Гадаад хүчин зүйл гэж бидний ярьдаг зүйл чухамдаа дотоод хүчин зүйл болсон үе.

Өгүүлэн буй үед нийгэм ангийн бүтцэнд өөрчлөлт гарч эхэлсэн. Таваар-мөнгөний харилцаа, жижиг таваарын аж ахуйн хөгжил нь феодалын дарлал, гадаадын худалдаачдын мөлжлөгт нэрвэгдсэн ардын аж ахуйтны дотоод задралыг хүчтэй болгож, хөрөнгө чинээний туйлшралыг нэмэгдүүлсэн нь биеийн хүчнээ үнэлэн амьдрах хэсэг

хүмүүсийг бий болгосон. Тэд хот суурин газрыг бараадан аж төрөх болсон нь хотын хүн амын нэг давхрааг бүрдүүлжээ. Эдгээрийн дотроос хөлсний ажилчид гарч байв. Үүний зэрэгцээ дундач давхраа бүрэлдэж эхэлсэн. Тэдний нийгэмд эзлэх байр суурь нийгэм эдийн засаг, аж ахуй, соёлын чанартай шинэтгэл хийхийг эрмэлзэн сонирхож байсан хүмүүсийн үйл ажиллагаагаар гол төлөв илэрч байв. Тэд хөрөнгө чинээ бүхий, феодалын алба татварт, харьцангуй бага нэрвэгдсэн хот хөдөөгийн этгээдүүд, өртөө харуулын албыг ацаглаж авах, хотын зах дээр мал түүхий эдийн наймаа хийх, хот хөдөөгийн хооронд панз хийх, жин тээврийн ажил эрхлэх, мөнгө хүүлэх, гадаадынхантай хорших, тэдэнд зуучлах зэргээр хөрөнгөө идэвхтэй арвижуулж тус орны эдийн засгийн амьдралд улам бүр нөлөө бүхий хүчин болж байлаа. Тэдний дотроос капиталист элементийн анхны төлөөлөгчид төрж байсны тоонд мэйрэн Дорж, лам Ёндонжамц, түшмэл Минбуу, түшмэл Цэдэвсүрэн нарыг хэлж болох ажээ.

Нэлэнхүйдээ нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын аж байдалд гарсан чухал өөрчлөлтийн нэг бол хотууд улс төр, засаг захиргаа, шашны төвийн зэрэгцээ гадаад, дотоод худалдаа, жин тээврийн төв зангилаа газрууд болж хүн ам нь өсөн хотын үүрэгт шинэ хандлага гарч дотоод зах зээлийн хувьд түүний гүйцэтгэх үүрэг эрс дээшилсэн явдал юм.⁽⁸⁾

Монголчуудын дунд орчин цагийн хөгжилтэй орнуудаас сурч гэгээрэх. Тэдгээр орны үлгэр загвараар улс орноо тохижуулан засах хүсэл их болж ирсэн нь соёл боловсролын талаар авч явуулсан зарим дэвшилтэт арга хэмжээнд тусгалаа олсон байдаг.

Манай орны соёл боловсролын түүхэнд чухамхүү энэ үед орчин цагийн иргэний сургууль, гэгээрлийн эх үүсвэр тавигдаж, өөрийн анхны тогтмол хэвлэлүүд гарч ирсэн нь монголчуудын үндэсний ухамсар, соёл боловсролын хэмжээг дээшлүүлсэн дэвшилт шинэ зүйл байлаа. Нийгмийн хөгжлийн дэвшилт зүй ёсоор соёл боловсролын салбарт дорвитой арга хэмжээ авахыг шаардаж байв. Чухамхүү энэ үед монголын нийгмийн сэтгэлгээнд дэвшилт ардчилсан үзэл санаа бүрэлдсэн Монголын сэхээтнүүдийн оролцоотойгоор Орос улсын байгууллагаас гаргаж байсан “Монголын сонин бичиг” ажээ. Түүнийг түгээн дэлгэрүүлэгч нь улсын дээд доод хурлын индэр, “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл Хүрээний сонин бичиг” зэрэг байлаа.

Хэрэв Хятадын Хувьсгалчид Японыг түшиглэн тэнд өөрсдийн хувьсгалт байгууллага болон дэвшилт хэвлэлээ гаргаж байсан бол Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэгчид Оросыг түшиглэж, дэвшилт ардчилсан үзэл санаа бүхий тогтмол хэвлэл гаргаж байсныг тэмдэглэвэл зохино.⁽⁹⁾

Ийнхүү XX зууны эхэн үед монголчууд өөрсдийн хийсэн шинэтгэл нь нийгмийн амьдралын бүх хүрээг хамарсан, тухайн үеийн хөгжлийн шаардлагыг тусгасан дэвшилт зүйл байв. Эдгээр нь бүхэлдээ монголын тал нутагт буй болж байсан нийгмийн шинэ шинэ харилцааны нөлөө бөгөөд хэдийгээр хийж эхэлсэн дээрхи шинэтгэл нь хагас дутуу, бас тэр бүр хэрэгжиж чадаагүй боловч монголын нийгмийн гүнд бүрэлдэж байсан дэвшилд тус түлхэц болжээ. Эдгээр шинэтгэл нь монголын нийгэмд олон зууны туршид оршиж байсан сэтгэлгээний консерватизм, улс төр, эдийн засгийн зогсонги царцанги байдлыг эвдэж, нийгэм цаашдаа хөгжил дэвшлийн замаар урагшлахад нэгэн

зүйл гараа болсон гэж хэлж болно. Шинэтгэлийн бодлого тасалдахад нөлөөлсөн дотоод гадаад хүчин зүйлүүд байсан. Ноёлогч ангийнхан хар гараараа талцан, засгийн эрх булаацалдаж байх явцад шинэтгэлийн бодлогыг явуулагч хар феодалуудыг төрийн эрхээс зайлуулж шар феодалууд элдэв шалтаг заан зарим нэг аж ахуй, соёлын шинэтгэлийн зүйл зогсоосон. Гурван улсын гэрээ нь засгийн газрын гар хөлийг хүлсэн. Монгол нь өөрөө тусгаар улсын хувьд өөрөө шинэтгэл хийх зам нь хаагдсан. Тиймээс ч монголын шинэтгэлд муугаар нөлөөлсөн.⁽¹⁰⁾ Хиагтын гурван улсын хэлэлцээр их гүрнүүд үеийн үед бага гүрнүүдийн хувь заяаг шийдэж байсан, нөгөө талаас бага буурай орнууд хүчирхэг том гүрнүүдээс байнгын хараат байдалд байдгийг харуулсан билээ. Гэхдээ Монгол улсын үед монгол оросын хоорондын харилцаа өргөжсөн нь монголын нийгэм эдийн засгийн байдалд үүсч байсан ахицтай өөрчлөлт, шинэ хандлагыг зарим талаар тэлэхэд нөлөө үзүүлсэн нь маргаангүй.

Монгол улсад хийгдсэн шинэтгэлийг XIX зууны сүүл үед Японд хийгдсэн “Мэйдзи”-гийн шинэтгэл, мөн Хятадын “Шинэчлэлийн 100 өдөртэй харьцуулбал нилээд ялгаатай. Япон, Хятадад хийгдсэн эдгээр шинэчлэл, шинэтгэл нь хөрөнгөтний ардчилсан шинэтгэлүүд байсан юм. Монголтой адилтгах зүйл; хаант засаглал байв. Ялгагдах зүйл: капиталист хэвшил аль хэдүйн бүрэлдэн, капиталын анхны хуримтлал ч явагдсан байсан нь хөрөнгөтний хувьсгал гарах объектив урьдчилсан нөхцөл бүрэлдсэн байжээ. Гэтэл монгол оронд капиталын анхны хуримтлал огт байхгүй, гадаадын капитал оруулалт маш бага, капиталист хэвшил бий болоогүй, гагцхүү феодалын нийгмийн үйлдвэрлэлийн харилцааны задрал нь хөгжлийнхөө ерөнхий хандлагаар шинэ харьцааны үр хөврөл соёолох хөрс дэвсгэр болж байв. Өрнөдийн орнуудад бол хөрөнгөтний ардчилсан шинэтгэлүүд хөрөнгөтний хувьсгал ялсны дараа хийгдсэн (англи, франц гэх мэт оронд). Харин орос оронд хамжлагат ёсыг халсны дараа буюу 1861 оноос хөрөнгөтний ардчилсан шинэтгэлүүдийг оросын хаант төр хийсэн.

Монгол улсын шинэтгэлийн бодлогыг уламжлалын утгаар үзвэл энэ шинэтгэлийн зүйл ардын хувьсгалын ардчилсан шатанд гүйцэлдсэн. Энэ ардчилсан шатны зорилт нь өмнөх үеэс улбаатай байсан.

III

Дундат иргэн улс өөрийн автономит гэгдсэн Ар Монголд явуулсан бодлого нь монголыг бүрэн хятадчилах бодлого буюу, өвөрмөц нэгэн “шинэтгэл” байлаа. Энэхүү бодлого хэрэгжүүлэхийн үүднээс Жабзундамба хутагт тэргүүтэй эрх баригчдыг эеэр татах бодлого, засгийн сүр хүч үзүүлэх зэрэг олон аргыг хэрэглэсэн.

Гадаад монголын өөрөө засах эрхийг устгасны хойно дундад засгийн газраас гадаад монголыг хүндэтгэх ба жич хойчийг сайжруулах хууль зүй” гэсэн нэртэй 64 зүйл бүхий баримт бичгийн үндсэн зүйл ангиуд нь автономийг устгаж, монголд Хятадын засаг захиргааг тогтооход бүрэн чиглэсэн ажээ. Манжийн ноёрхлын үед монголын феодалуудыг өндөр цалин фүнлүү, цол хэргэм олгох замаар өөртөө татдаг уламжлалт бодлого хятадууд энэ удаа ч хэрэглэжээ. Монголын феодалуудын эдлэх эрх ямбыг тодорхой зааснаас гадна тэднийг талдаа

татаж чадахуйц хэд хэдэн шинэ зүйл анги оруулсан. Жишээ нь: Дундат иргэн улсын хуралд монголын засаг ноёдын төлөөлөгчдийг оролцуулах: Монгол, Төвдийн хэрэг эрхлэх ерөнхий газрын орлогч ба жинхэнэ даргын тушаалд монгол засаг ноёдоос томилж байх, хятадын төлөөний сайдын дэргэд гадаад монголын хэргийг хэлэлцэх монгол ноёдын зөвлөлгөөнийг байгуулах, Богд гэгээн хэрэв онцгой ноцтой хэрэг гарвал ерөнхийлөгчид шууд өргөх эрхтэй гэх мэт.

Чэнь И-гийн 64 зүйлд шар феодалуудын эрх мэдлийг хязгаарлах талаар нилээд зүйл орсон учраас лам нарын дээд ангийн зарим хэсэг хүнийг дургүйцэж байлаа. Ард түмэнд ашигтай нэг ч зүйл дурьдагдаагүй, харин ч алба татвар, өр шир төлөх нь хуучин хэвээр үдэж, Хятадын мөнгө хүүлэгчид ард олноос хуучин өрийг нэхэн хураах тухай заасан нь уг зүйлийн харгис чанарыг илэрхийлнэ.

Урьд монголчууд “шинэ засгийн бодлогыг” хүлээн авахгүй гэж эсэргүүцэж байсан шигээ энэ удаа ч ДИУ-д дагаар орохыг шийдэмгий эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн нэртэй, нэргүй бичиг Их Хүрээний гудамж, зах зээлийн газар тарааж байжээ.⁽¹¹⁾ Аз болоход Чэнь И-гийн 64 зүйл хэрэгжих тавилангүй байв. Харин түүнийг хүчингүй хэмээн зарлан “Монголын хойчийг сайжруулах 8 зүйл” гэдэг төслийг Баруун Хойт Хязгаарын Хэргийг бодуулан шийтгэх сайд гэгч Сюй Шучжэн гаргаж ирсэн нь мөн л монголыг шууд колоничлох оролдлогын бас нэгэн хувилбар байв. Монголд хийх шинэтгэлийн хөтөлбөрийн үндсэн чиглэлийн дагуу монгол дахь хятадын захиргаа ажиллаж эхэлсэн юм. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 1920 оны хавар Засгийн хэргийг дэлгэрүүлэн хөгжүүлэх тухай их хурал хийлгэхээр халхын олон ноёд түшмэлийг хүрээнд ирүүлж хуралдуулсан боловч үүнээс ямар ч ашиг гараагүй энэ удаа хятадын цэргийн эрхтнүүд монголын эрх баригчидтай хэлэлцээр хийх биш, харин өрсдийн шинэтгэлийн төслийг шууд тулган хүлээлгэх балмад аргыг хэрэглэн автономийг устгаж 8 зүйлээ хэрэгжүүлж эхэлсэн нь мөн л монголыг хятадчилах бодлого байлаа. Иймээс ч монголчууд урьдынхаасаа илүү зохион байгуулалттай, илүү нарийн аргаар үндэснийхээ эрхийн төлөө дахин босч тэмцэхдээ оросын цагаан, улаан хоёр хүчний зөрчлийг ашиглан, цагаантнаар Хятадын гэмн эргийн гол хүчнийг цохиулж, улаантныг ашиглан цагаантан ба хятадын цэргийн үзэгдлийг бут цохиж тусгаар тогтнолоо дахин олж авсан нь монголчуудын улс төрийн зөв мэргэн бодлого гэж үзүүштэй. Үүгээр Хятадаас Монголд XIX гэсэн шинэтгэл төгсгөл болсон.

XX зууны эхний 20 жилд гурван дор төрөөс Ар Монголд хэрэгжүүлэх гэсэн ШИНэтгэлийн ба 3 дахь нь Манж Чин улс, Дундад Иргэн Улсаас хийхийг завдсан өөрчлөлт шинэтгэл нь монголчуудаар биш харин хятадуудаар хийлгэж тус орныг бүрэн колончилох, хүн амы нь хүчээр уусгахад чиглэж байсан бол шинэтгэлийн хоёр дахь нь Монголчуудыг шамдуулан тусгаар тогтносон улсад зайлшгүй байх ёстой улс төр, эдийн засаг, соёлын салбарыг хамрах төлөвтэй байлаа. Гэтэл хоёр их гүрний хавсайдах бодлогын урилгаар төрийн тусгаар тогтнол тун охор наслаж, ДИУ-ын харъяаны автономит орон болсон нөхцөлд нэгэнт эхлэсэн шинэтгэл нь 1919 онь эцэс хүртэл зарим талаар явагдсан нь монголчууд өөрсдийн хүч бололцоог шавхан дайчилбал улс орноо сэргээн мандуулах чадвартайг харуулсан билээ.

Манай улс нээлттэй бодлого явууж ергон хүрээтэй өөрчлөл шинэтгэл хийж биеэ дааж дэгжрэх чиглэл тууштай баримтлаж байгаа өнөөгийн нөхцөлд, ХХ зууны эхээр манай оронд шинэтгэл хийх гэж байсан оролдлогыг судлах нь танин мэдэхүйн ач холбогдолтой төдийгүй түүхэн сургамжтай юм.

Эшлэл, зүүлт

1. 1898 онд Хятадын эрдэмтэн хаан Ювэй болон түүний талынхан хөрөнгөтний шинэтгэлүүд хийхээр оролдлого хийсэн юм.
2. Э.Д.Гримм. Сборник договор и других документов по истории международных отношений на Дальнем Востоке (1842-1923) М., 1927. 148-149.
3. УННС. Дархан ван Пунцагцэрэнгийн гар бичмэл.
4. УТТА. ФМ-9. ХН 3987, 429-430-р нүүр.
5. УТТА. ФМ-9, ХН 3687, 3690, ХН-9.
6. УТТА. ФМ-9, ХН-11.
7. “Страны Востока в политике России в XIX-XX вв. Ир., 1986.
8. С.Идшинноров. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм эдийн засгийн зарим асуудал. УБ., 1987, 50-р тал
9. Г. Дэлэг. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ., 1965. 100-р тал.
10. Б.Санжмятав. Гурван улсын хиагтын гэрээний тухай түүхэн үнэн. УБ., 1991
11. Л.Дэндэв. Монголын товч түүх. УБ., 140-р тал.

(1911 ОН) ГАДААД МОНГОЛЫН
АВТОНОМИЙГ УСТГАСАН НЬ

Е.А.Белов.

Энэ асуудал харьцангуй бага судлагдсан. Тухайлбал, Зөвлөлт, монголын түүхчдийн хамтын “БНМАУ-ын түүх” бүтээлд энэ асуудлыг хөндсөн. Уг бүтээл, Монголын феодал, ноёдын “өчүүхэн дээдэс” Октябрийн Социалист хувьсгал Гадаад Монголд нөлөөлөхөөс эмээж, 1919 онд монголын автономит эрхийг устгахыг зөвшөөрсөн⁽¹⁾ гэсэн үндсэн дүгнэлтэд хүрсэн байна. Гэвч бүх юм бодит нөхцөл байдал дээр илүү нарийн төвөгтэй байсан юм. Монголын «феодалуудын Октябрийн хувьсгалын нөлөөнөөс эмээсэн айдас Гадаад Монголын автономийг устгахад хүргэсэн гол шалтгаан хараахан биш байв.

Академич Б.Ширэндэв нэгэн бүтээлдээ 1918-1919 оны Монголын түүхэнд, холбогдох⁽²⁾ ОХУ-ын архивын (цаашид ГАРФ, хуучны ЦГАОР) сонирхолтой баримтууд гаргаж тавьсан хэдий ч тэдгээр баримтаа эмх замбараагүй иш татаж авснаас уншигчид Гадаад Монголын автономийг устгахад нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар ойлголт авахад төвөгтэй болсон тэр ч бүү хэл чухам ямар хүчин зүйлс гадаад монголын автономийг устгах явдлыг эхлүүлсэн болохыг ойлгохын аргагүй болгожээ.⁽³⁾ Тиймээс урьд хэвлэгдэж байгаагүй оросын архивын баримтанд тулгуурлан дээрх асуудлыг бодитой авч үзэхийг оролдлоо.

Гадаад Монгол нь ард түмнийхээ үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний явцад, өөрийн болоод монголчуудын ашиг сонирхлын үүднээс Хятадад дипломат болон цэргийн даралт шахалт үзүүлж